

ЧИМЭДДОРЖИЙН ДАШНЯМ БОЛ СЭТГҮҮЛ ЗҮЙ СУДЛАЛЫГ
ҮНДЭСЛЭГЧДИЙН НЭГ МӨН

Б.Уянга*

* «Улаанбаатар Эрдэм» их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, докторант

Түлхүүр үг: гучаад оны тогтмол хэвлэл дэх утга зохиол, сэтгүүл зүйн шүүмж судлал, сэтгүүл зүй судлал, Ч.Дашнямын нийтлэлийн шүүмж бичиг

Хүний амьдралын асар богино хугацаанд аж төрсөн ч уран бүтээлээ урамтай сайхнаар туурвиж чадсан Монголын орчин үеийн уран зохиол, сэтгүүл зүйн томоохон зүтгэлтний нэг бол яах аргагүй Чимэддоржийн Дашням юм. Тэрээр хэтэрхий идэр залуу насандаа хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн ч Монголын уран зохиол, сэтгүүл зүйд чамлахааргүй ихийг бүтээж үлдээжээ.

Тэрээр 1912 онд Буриадын Хишинг нутагт ард Чимэддоржийн гэрт мэндэлжээ. 1923 онд эцэг, эхийн хамт Монгол нутагт нүүж ирсэн бөгөөд улмаар эрдэм номд шамдан боловсорч, ихийг бүтээх зам нь нээгдсэн байна. Төрөлхийн авьяас билэгт бяцхан хүү Улаанбаатар хотод бага сургуульд суралцан, улмаар 1924-1928 онд дунд сургууль дүүргэжээ. Дунд сургууль төгссөн 16 сурагчаар багш бэлтгэх дөрөвдүгээр ангийг бүрдүүлж, хэдэн сарын хугацаанд багшлах дадлага хийлгүүлж, 1929 оны 3-р сарын 29-нд Ардыг Гэгээрүүлэх Яамнаас

үнэмлэх бичиг шийтгэн олгож, Ч.Дашнямыг багшаар томилжээ. Ингэж тэрээр дунд сургуулийн анхны багш нарын нэг болжээ. Ажил амьдралын замаа арван долоохон насандаа эхлүүлсэн Ч.Дашням “Залуучуудын үнэн” сонины сурвалжлагч, “Хувьсгалт залуучуудын эвлэл” сэтгүүлийн хариуцлагатай эрхлэгч болж дэвшсэн байна. Тэрээр 1934-1937 онд Цэргийн ерөнхий сургуульд багшилж байв.

Ч.Дашням нь бага балчир наснаасаа ном зохиолд шимтэн дурлаж, бие даан уншиж, судалж эхэлсэн бөгөөд бичиж туурвих билиг авьяас нь их эртээс оргилон нээгдсэн байна. Ч.Дашням олон тооны сурах бичиг, эрдэм шинжилгээний ном, өгүүлэлд, тэрчлэн уран зохиол, орчуулгын зохиол болон жүжгийн зохиолд хүртэл шүүмж бичжээ. Түүний анхны шүүмжийн бүтээл нь “Шинэ цагт шинэ дуу хэрэгтэй” хэмээх өгүүлэл юм. “Үндэсний хувьсгалт улаан цэргийн суралцах тоо бодлогын дэвтэр” (1936 он), “Одон орны тухай яриа” (1933 он), “Олон улсын дэлхийн байдал” (1933 он), “Нар, од хоёрын аль нь том бэ?” гэх мэт эрдэм шинжилгээний өгүүлэл, “Саяхан гарсан шинэ жүжиг”, “Унтсан нэг сэтгүүлийн тухай” гэх мэт олон шүүмж бичиж хэвлүүлжээ.

Уран зохиол судлагч Ц.Банзрагч түүний уран бүтээлийг 1930-аад оны эхний хагас, 1930-аад оны хоёрдугаар хагас хэмээн үндсэнд нь хоёр хэсэгт ангилж үзсэн байна. Эхний хагасад буюу нэгдүгээр үе шатандаа Ч.Дашням уран зохиолын явцыг бүхэлд нь хамарсан шүүмж бичиж байсан бол хоёрдугаар үедээ уран зохиолын онол, түүхийн асуудлыг хөндсөн өгүүлэл, тодорхой нэг зохиолын шүүмжийн зэрэгцээ театр, кино, хөгжим зэрэг урлагийн олон төрлийг хамарсан уран сайхны шүүмж бичих болжээ гэж Ц.Банзрагч дүгнэсэн байна. Түүний бүтээлүүдтэй нарийвчлан танилцаж судлан үзэхэд сүүлийн хагасад бичсэн шүүмжүүд нь өнгө аяс, утга санаа, төрөл зүйлийн хувьд илүү нарийсч, боловсронгуй болсон нь илэрхий ажиглагдаж байна. Энэ үеийг Ч.Дашнямын уран бүтээлийн ид цэцэглэлтийн үе гэж бүрэн үндэстэй хэлж болно. Тэрээр 1931-1937 оны хооронд 30 гаруй шүүмж бичсэн бөгөөд эдгээр нь уран зохиол, шүлэг, дуу, жүжгийн олон зохиолыг хамарчээ. Жишээлбэл: "Шинэ цагт шинэ дуу хэрэгтэй" хэмээх шүүмждээ: "Жийжүү хот" зэргийн дуу бол бидний шинэ өсч буй хүчинд ямар ч хүмүүжлийг өгч чадахгүй бөгөөд "Жийжүү бадам", "Саарал хөнжил дэлгээстэй еэ" зэргийн хөрөнгөтний буюу феодалын завхай дуу нь манай уриалж буй шинэ үеийг буруугаар удирдана" гэж шүүмжилсэн байна. Мөн Монголын анхны дуу бүхий "Монгол хүү" киноны "Монгол хүүд Монголоос өөр нутаггүй" хэмээх шүүмждээ: "Манай монгол жүжигч нар бол театрын тайзан дээр тоглож байснаас бус кинонд тоглож байсан туршлагагүй боловч үнэхээрийн сайнаар тоглож чадсанаас гадна тус кино нь өргөн түмнийг сонирхуулах чадалтай сайн

кино болж чаджээ. ...Киноны өргөн утга нь янаг амрагийн хүслийг гол болгосон бус, харин эрх чөлөөт Монголын сайхан орон ба эрх чөлөөгүй дотоод монгол хоёрын хоорондох ялгаврыг тодорхойгоор илрүүлсэн улс төрийн гүн утгатай кино мөн" гэсэн байна. Тэрбээр цааш нь: "Энэхүү анхны монгол киноны туршлагаар дахин шинэ сайн кино зохиогдох буй за хэмээн итгэх бөгөөд Трауббергээс дахин дахин сайн кино үйлдэе хэмээн өгүүлж байсан билээ. "Монгол хүү" бол СССР, Монгол хоёрын хөдөлшгүй найрамдал ба соёл боловсролын харилцаа холбоо, тусламж улмаар батжин өргөжиж байгаагийн нэгэн амжилт болно" хэмээн дүгнэсэн байна. Үүнээс үзэхэд түүний шүүмжийн төрөл зүйл нь ганц уран зохиол, шүлэг төдийгээр хязгаарлагдаагүй бөгөөд урлагийн өөр төрлүүдээр ч ур чадвартай сайн шүүмж нэг бусыг бичиж үлдээсэн нь харагдаж байна.

Ч. Дашням нь зөвхөн уран зохиол судлаач, шүүмжлэгч байсан төдийгүй, Монголын сэтгүүл зүйг, тухайлбал тогтмол хэвлэлийн нийтлэлийн бодлогыг залж чиглүүлэхэд өөрийн хувь нэмрийг зориулсан сэтгүүл зүйн анхдагч судлаачдын нэг юм. Тэрээр 1928 онд багшийн сургууль төгсөөд "Залуучуудын үнэн" сонинд сурвалжлагчаар ажиллах болсноор сэтгүүл зүйд хүчээ сорьж эхэлсэн байна. Нийтлэлийн талаарх түүний шүүмж нь Монгол дахь сэтгүүл зүйн шүүмж, судлалын эхлэлийг тавьжээ. Тэрээр "Үнэн", "Ардын эрх", "Залгамжлагч", "Шинэ толь", "Монголын ардын соёлын зам" зэрэг тогтмол хэвлэлд цөөнгүй шүүмж бичиж хэвлүүлжээ. Ингэснээр Ч.Дашням Монголын сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлд уран бүтээлийн шүүмж хэмээх бичлэгийг

эрчимтэй оруулж ирж чадсан юм. Тэрээр шүүмжүүддээ тухайн бүтээлийн алдаа дутагдлыг үнэнээр нь өгүүлдэг байжээ. Хэдийгээр Ч.Дашням сайн шүүмж цөөнгүйг бичиж байсан хэдий ч зарим шүүмжүүд нь үнэнд төдийлөн нийцэхгүй, хэтэрхий явцуу хүрээнд эргэлдэж байсан гэж үзэх ч үндэс бас бий. Ч.Дашням шүүмжээ тогтмол хэвлэлд нийтлүүлэхдээ: "Өөрийн бодсон шүүмжийг олон нийтийн шүүмжлэлд толилуулав" хэмээн нээлттэй орхиж, бусад хүмүүсийн санаа бодлыг уралдуулдаг байсан нь бидний сонирхлыг онцгой гойдоор татаж байна. Энэ бол шүүмж судлалыг хөгжүүлэх гэсэн түүний нэг оролдлого байж бүрэн болох юм.

Ч.Дашнямын бичсэн шүүмжүүд нь хурц дайчин үг хэллэг, өнгө аястай, утга төгс, үгийн уран яруу хэрэглүүрийг тусгаж байснаараа онцлог юм. Мэдээж тэрбээр тухайн цаг үеийнхээ ангич, намч үзэлд үнэнч байсан нь ойлгомжтой. Энэ нь ч "Жийжүү хот" дууны утга агуулгыг шүүмжилснээс нь харагдаж байна. Гэхдээ бүх шүүмж нь ийм байгаагүй билээ. "Унтсан нэг сэтгүүлийн тухай" хэмээх шүүмждээ Ч.Дашням "Монгол ардын үндэсний соёлын зам" хэмээх сэтгүүлийн нийтлэлийг шүүмжилсэн бөгөөд ард түмний дурлаж уншдаг байсан өнгө будаг бүхий сайн сэтгүүлийн чанар нь эрс муудаж, үр өгөөж муутай, үзэмж төдий хавтаснаас өөр юм үгүй болсон, хоёр дугаарыг нэг дугаар болгон хэвлэн

оромддог болсон тухай эрс шийдэмгий шүүмжилж байсан байна. Энэ нь тогтмол хэвлэл бол уншигчдын хүсэн хүлээн уншдаг сонин, сэтгүүл байж тогтмол цаг хугацаанд тэдэнд хүрдэг байхаас гадна мэдээ мэдээлэл, нийтлэлүүд нь агуулгаар баялаг, ард түмний оюун санааг тэжээн тэтгэгч, удирдан чиглүүлэгч байх ёстой гэсэн санааг илэрхийлжээ.

Ч.Дашням нь энэ мэтээр уран зохиол, урлаг, сэтгүүл зүйн бүтээлүүдэд шүүмж бичээд зогсохгүй танин мэдэхүйн чиглэлтэй олон арван мэдээ, өгүүлэл бичиж, тэрчлэн гадаадын уран зохиолоос орчуулан гаргаж байжээ. Энэхүү танин

«
Ч.Дашням Монголын сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлд уран бүтээлийн шүүмж хэмээх бичлэгийг эрчимтэй оруулж ирж чадсан юм. Хэдийгээр Ч.Дашням сайн шүүмж цөөнгүйг бичиж байсан хэдий ч зарим шүүмжүүд нь үнэнд төдийлөн нийцэхгүй, хэтэрхий явцуу хүрээнд эргэлдэж байсан гэж үзэх ч үндэс бас бий.

»

мэдэхүйн чиглэлтэй нийтлэлүүд нь Монголд сэтгүүл зүйн танин мэдүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадахуйц байсан гэдгийг тэмдэглэн хэлэх зүйтэй юм.

Түүний бичиж туурвисан "Газраас од хүртэл хэдэн километр байдгийг чи мэдэх үү?", "Огторгуйд хэчнээн од байдгийг мэдэх үү?" өгүүлэл, "Гадаад далай дахь замууд" том хэмжээний өгүүлэл, "Анааш хэмээх гөрөөс" гэх мэт нэлээд тооны танин мэдэхүй, гэгээрүүлэх өнгө аяс бүхий нийтлэл нь тухайн цаг үедээ шинэ сэргэг өнгө аястай, танин мэдүүлэх өндөр ач холбогдолтой сэтгүүл зүйн бичлэгийн шинэ үлгэрлэгч загварыг буй болгосон байна. "Шинэ толгойгоо арван толгойт хэмээхийн урьтгал" гарчигтай танин мэдэхүйн шинжлэх ухааны хялбар-

шуулсан шинжтэй өгүүлэлдээ Ч.Дашням "Хэрэв би ямар нэгэн шалтгаанаар хөлөө гэмтээж тасалбаас насан турш хөлгүй болж, ямар нэгэн бүдүүлэг амьтанд атаархан, түүнтэй адил чадалтай болоосой хэмээн гомдох байсан билээ. Учир нь тэр зэргийн бүдүүлэг доорд амьтанд ямар нэг аюултай дайсан довтолж, түүний хөлийг тас татсан аваас хэдэн өдөр өнгөрөхөд түүний хөлийн сууринд нэг мах товойн ургаж, бас баахан удвал хөл болон гүйцэлдэж, хуруутай болно. Дайсны ходоодонд шингэсэн хөөрхий хөлнөөс дутуугүй болно. Энэхүү үзэгдлийг шинжлэх ухаанд регенерац гэх бөгөөд чухам монгол үгэнд юу гэж нэрлэхийг би орчуулагч бусын учир тулгаварлан үл мэдэх бөгөөд ерийн үгэнд шинээр ургах гэсэн утгатай бөлгөө" гэх мэтээр бичсэн байна.

Мөн "Газраас од хүртэл хэдэн километр байдгийг чи мэдэх үү?" хэмээх мэдээлэлдээ дэлхий, од хоёрын хооронд хэчнээн километр зай байдаг вэ, тэнгэрийн зүүдэл гэж юу вэ зэрэг асуултанд энгийн үгээр тайлбарлан уншигч олонд ойлгогдохуйцаар хялбарчлан бичсэн байдаг бөгөөд утга агуулга төгс, ямар ч насны хүн түвэггүй ойлгохоор амьдралд нийцүүлж тайлбарлан бичсэн байдаг. Жишээлбэл: тэнгэрийн зүүдэл гэдгийг тайлбарлахдаа "Хав харанхуй шөнө дээшээ харвал тэнгэр нь цагаан зүүдэлтэй мэт харагдана. Үүнийг урьд цагт бүдүүлэг хүмүүс тэнгэрт нэг амьтан сүү асгаж байна гэлцдэг байсан. Энэ нь туйлын буруу бөгөөд харин дурангаар шинжлэн харвал тэрхүү зүүдэл туйлын олон тооны хэсэг однууд нийлж харагдахдаа тийнхүү зүүдэл мэт үзэгдэнэ" гэжээ. Эдгээрээс харахад Ч.Дашням нь сэтгүүл зүйн танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх үүргийг гүйцэтгэсэн нийтлэ-

лүүдийг ур хийц сайтай, утга агуулга төгс, үг хэллэгийн яруу тунгалаг, тод томруун дүрслэлтэй бичдэг байсныг харж болох юм.

Ч. Дашням шүлэг хэмээх зүйлийн утгыг шүүмжлэн таниулсан нь одоогийн бидний мэдээ бичлэгийн шинж чанарт нийцэхүйц бичсэн мэт санагдаж байна. "Залуучуудын эвлэл" сэтгүүлийн 1936 оны №3 дугаарт Ч.Дашням "Цэцэг услах хэрэгтэй" хэмээх шүүмжээ толилуулжээ. Энэхүү шүүмжид: "Олон нийтийн дотор болж бүхүй ямар нэгэн үзэгдлийг зөв бөгөөд хурц үгээр цаг тухайд нь зохиол болгон чадваас уран зохиол нь нам, засгийн зорилго бодлогыг биелүүлэгч ба эх төлөөнөө жинхэнэ тэмцэгч болж чадах бөгөөд ийм чанарын уран зохиол шүлэглэлүүдээр бид нар арвин ба амжилт ихтэй болой. ...Хэдийгээр бид энэ талаар амжилттай боловч өдөр тутмын ажил дотроос үүсэн гарч буй бүхүй үзэгдэл лүгээ уялдуулж түүнийг ашиглахгүй харин ерөнхий өгүүллээр зорилгыг бичих ба зөвхөн толгой холбохыг урьтал болгох явдлууд олонтаа үзэгдмой. ...Түүнээс гадна шүлэг зохиолоор суртлыг нэвтрүүлэхдээ юуны өмнө өдөр тутам үзэгдэж буй бодит материалыг жишээ болгон түүгээр үндэс болгох нь чухлын дээр бас нэгэн чухал зүйл нь үг цөөн, утга хурцтай, богино байваас зохих амой" гэжээ. Үүнээс харахад өнөөгийн сэтгүүл зүйн мэдээний үйл явдлыг цаг алдахгүй түргэн шуурхай мэдээлэх, товч бөгөөд тодорхой, үг хэллэг цэгцтэй, богино байхын дээр бодит баримт материал дээр тулгуурлана гэсэн үндсэн шинж чанарыг дээрх шүүмжид бүрэн утгаар гарган тавьж чадсан байна.

Дээр дурдсан бүхэн нь судлаач Ч.Дашням зөвхөн өнгөрсөн зууны

гучаад оны Монголын уран зохиол, урлагийн бүтээлүүдийн талаарх шүүмжлэгч төдийгүй, Монголын сэтгүүл зүйд өөрийн хувь нэмрийг оруулсан, сэтгүүл зүйн мэргэжлийн шүүмж судлалыг үүсгэн хөгжүүлэхэд бүтээл туурвилаараа хүчтэй нөлөө үзүүлсэн томоохон төлөөлөгчийн нэг юм гэсэн дүгнэлт хийх боломжийг бидэнд олгож байна.

Ч Дашням нь 1938 онд хилс хэргээр баривчлагдан арван жилийн хорих ялаар шийтгэгдээд, хүнд өвчний улмаас 1940 онд 28-тай цэл залуу насандаа шоронд бие барсан гэсэн мэдээлэл байдаг. Тэрээр богинохон амьдралынхаа ид эрч хүчтэй, авьяас билиг ундрэн оргилж байсан үедээ Монголын урлаг, уран зохиол болон сэтгүүл зүйд асар ихийг бүтээснийг түүний бичиж туурвиж үлдээсэн цөөнгүй шүүмж, өөр бусад нийтлэл нь гэрчилнэ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Дөтгөөр дэвтэр. УБ.
2. Банзрагч Ц. 2001. Чимэддоржийн Дашням. Намтар, уран бүтээл. УБ.
3. Норовсүрэн Л. XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ 2012.
4. Норовсүрэн Л. Монгол хуучин сонин, сэтгүүлийн товч лавлах. УБ. 2012.
5. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.
6. Лувсанвандан С., Мөнх Ц. 1986. Монголын орчин үеийн уран зохиолын онол түүхийн асуудалд. УБ.
7. "Ардын үндэсний эрх", 1936, №99.

Резюме

В этой статье автор затронула важную тему возникновения и развития литературной критики в Монголии, в том числе журналистского исследования в области СМИ. На основе анализа критических рецензий Ч.Дашняма автор пришла к выводу, что он является одним из основоположников изучения журналистского наследия в Монголии.